



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 1/46

Шивээговь сум

Төсөл, арга хэмжээг төлөвлөхөд  
арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсгийг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөхөд арга зүйн зөвлөмж өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Гишүүд:

Засаг даргын орлогч

1 дүгээр багийн Засаг дарга

2 дугаар багийн Засаг дарга

Санхүүгийн албаны дарга

Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн

Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн

төлөвлөлт, менежемент, малын үржил

бүртгэлийн асуудал хариуцсан

мэргэжилтэн

Бэлчээр, газар тариалангийн асуудал

хариуцсан мэргэжилтэн

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Байгаль орчны асуудал хариуцсан

мэргэжилтэн

42124 112

Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны  
асуудал хариуцсан мэргэжилтэн

Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Хөрөнгө оруулалт, эдийн засаг  
төлөвлөлт, худалдан авах ажиллагаа  
хариуцсан мэргэжилтэн

2. "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд иргэдээс гарсан саналыг багцлах, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах, дүн шинжилгээ хийх ажлыг хэрэгжүүлэн багийн Иргэдийн нийтийн хурлаас ирүүлсэн саналыг нэгтгэж, санал нэг бүрийг хэлэлцэн дүгнэлт гаргаж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг бэлтгэн Засаг даргын зөвлөлд 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА